

ЯВЦЫН ТАЙЛАН

2024 оны 5-р сарын 21- 6-р сарын 12

2024 оны 6-р сарын 14

I. ХУРААНГУЙ

- 6-р сарын 28-ны өдөр болох Улсын Их Хурлын сонгууль нь Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу, парламентын (*Улсын Их Хурал*) бүрэлдэхүүнийг мэдэгдэхүйц нэмэгдүүлж, олон талт байдлыг хангахад чиглэсэн сонгуулийн холимог тогтолцоогоор зохион байгуулагдах юм.
- АИХЭГ-ын САХ-ны ярилцсан хүмүүсийн дийлэнх нь сонгуулийн шинэ тогтолцоонд эерэг хүлээлттэй байгаа боловч шинэ сонгуулийн тойрог нь сонгуулийн албан ёсны сурталчилгааны богино хугацаанд орон даяар хүрч ажиллах хүчин чадалтай голлох улс төрийн намуудад илүү давуу талтай гэдэгт санаа зовж байгааг илэрхийлж байв. Энэ удаагийн сонгууль олон нийтийн анхаарлыг татсан авлигын хэргүүд, хөдөөгийн малчдын эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд явагдаж байна.
- 2023 онд УИХ-ын сонгуулийн хууль тогтоомжид өргөн хүрээний нэмэлт, өөрчлөлт оруулж, сонгуулийн тов зарлагдсаны дараа байгуулагдсан намуудад нэр дэвшүүлэх бололцоог олгож, нэр дэвшигчийн хүйсийн квотыг нэмэгдүүлж, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх санаачилгыг дэмжсэн санхүүгийн хөшүүрэг бий болгосон зэрэг нь АИХЭГ-аас өмнө нь гаргасан зөвлөмжүүдтэй нийцэж байна. Гэвч, санал өгөх, нэр дэвших, үг хэлэх эрх чөлөөг хязгаарлалт, хуулийн цоорхой, ойлгомжгүй байдал байсаар байна. Үндсэн Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу УИХ-ын 78 гишүүн 13 тойрогт мажоритар, 48 гишүүн пропорциональ тогтолцоогоор Монгол Улсын нийт нутаг дэвсгэрээс сонгогдоно.
- Сонгуулийг дөрвөн шатлалтай сонгуулийн байгууллага зохион байгуулдаг ба Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ) нь сонгуулийн үйл явцад хяналт тавих байнгын ажиллагаатай байгууллага юм. Энэ удаагийн сонгуулийг зохион байгуулахад, СЕХ аймаг, нийслэлийн 22 сонгуулийн хороо, сум, дүүргийн 339 сонгуулийн хороо, хэсгийн 2198 хороог байгуулжээ. Сонгуулийн албан тушаалтныг цахим хэлбэрээр сургалтад хамруулах, гэрчилгээ олгох цогц, цахим сургалтын системийг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор сонгуулийн хэсгийн хороодыг байгуулах ажиллагаа удааширсан ч тэдний ажилд нөлөөлөөгүй. АИХЭГ-ын САХ-ны ярилцсан хүмүүс ерөнхийдөө сонгуулийн байгууллагын үйл ажиллагаанд итгэж байгаагаа илэрхийлсэн ч сонгуулийн санал тоолох төхөөрөмжид эргэлзсээр байна.
- Шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүйд тооцогдсон болон хорих ял эдэлж байгаа хүмүүсээс бусад, санал хураах өдөр 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн бүр санал өгөх эрхтэй. 5-р сарын 28-нд Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас сонгуулийн насны нийт 2 сая 238 мянга 360 иргэн байгааг зарласан. АИХЭГ-ын САХ-ны ярилцсан хүмүүсийн зарим нь олон тооны сонгогчийг сонгуулийн зорилгоор өөр тойрог руу шилжүүлэх шахалтад өртөж байгаад санаа зовж буйгаа илэрхийлэв.
- Хууль тогтоомжид, санхүүгийн болон эрх зүйн чадамж гэх мэт хэд хэдэн хязгаарлалт тогтоожээ. Улс төрийн нам, эвслүүд сонгуулийн санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө СЕХ-нд сонгуульд оролцох тухайгаа мэдэгдэх, мөрийн хөтөлбөр нь төрийн бодлого,

үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэх талаар Үндэсний Аудитын Газраас зөвшөөрөл авах ёстой. Шинэчлэн найруулсан хуулиар сонгууль зарласны дараа байгуулагдсан намуудыг нэр дэвшүүлэхийг зөвшөөрсөн. Зургаадугаар сарын 10-ны өдөр нийт 19 нам, 2 эвсэл, бие даагч 42 нийт 1336 нэр дэвшигчийг бүртгэсэн тухай СЕХ-ноос мэдээлэв.

- Сонгуулийн хууль тогтоомжоор сонгуулийн сурталчилгааг хатуу чанд, зааварчилсан байдлаар зохицуулдаг. Албан ёсны сурталчилгааны хугацаа зургаадугаар сарын 10-ны өдрөөс эхэлсэн хэдий ч, сонгуулийн өмнөх сурталчилгааны хэд хэдэн тохиолдол гарсныг АИХЭГ-ын САХ-нд мэдээлсэн байна. Хуулийн хязгаарлалтаас үл хамааран, Засгийн газар оны эхнээс хэд хэдэн халамжийн шинэ хөтөлбөрүүд зарласанд санаа зовниж буйгаа АИХЭГ-ын САХ-нд ярилцлага өгсөн хүмүүс илэрхийлэв. Сонгогчдын саналыг худалдаж авах, бэлэн мөнгө тараах, төрийн албан хаагчдыг дайчлах, дарамтлах зэрэг асуудал санаа зовниулсан хэвээр байна. Мөн, төлөөллийг хангах зорилгоор цөөнхийн хэлээр сонгуулийн сурталчилгаа явуулахыг зөвшөөрдөг.
- Жендэрийн тэгш байдал Үндсэн Хуулиар баталгаажсан ч улс төр дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй хэвээр, жендэрийн хэвшмэл ойлголт, хязгаарлагдмал нөөц нь саад учруулсаар байна. Эмэгтэй нэр дэвшигчдэд тулгардаг томоохон сорилтуудын нэг нь нөөцтэй холбоотой. Сүүлд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нийт нэр дэвшигчдийн хүйсийн квотыг 30 хувь болгох, пропорциональ жагсаалтад жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх санхүүгийн хөшүүргийг бий болгосон.
- Сонгуулийн сурталчилгааны санхүүжилтэд хяналт тавих үүрэгтэй ҮАГ нь сонгуулийн тойргийн хэмжээ болон сонгогчдын хүн ам зүйд тулгуурлан сурталчилгааны зардлын дээд хязгаарыг тогтоодог. АИХЭГ-ын САХ-ны хэд хэдэн ярилцагч эдгээр хязгаарыг өндөр гэж үзэж, парламентад суудалтай намуудад давуу тал болно хэмээн тэмдэглэжээ. Сонгуульд өрсөлдөгчид сонгуулийн өмнөх болох дараах хандив, зардлын тайлангаа ҮАГ-т ирүүлэх үүрэгтэй ч ҮАГ нь аливаа зөрчилд хуулийн хүрээнд хариуцлага тооцох зохицуулалт байхгүй.
- Монголын хэвлэл мэдээллийн орчин харилцан адилгүй, олон янз боловч АИХЭГ-ын САХ-ны ярилцсан маш олон хүн улс төрийн хамаарал, эдийн засгийн дарамт нь редакцын хараат бус байдалд сөрөг нөлөөлж буйд зовниж буйгаа илэрхийлжээ. МҮОНРТ-д олон нийтийн итгэх итгэл харьцангуй өндөр, нэр дэвшигчдэд эфирийн цагийг үнэ төлбөргүй олгох үүрэгтэй; төлбөртэй улс төрийн сурталчилгааг зөвхөн хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулахыг зөвшөөрнө. Өргөн нэвтрүүлгийн болон онлайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хяналтыг үндсэндээ Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ) хариуцах бөгөөд тус хороо нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх зэрэг хориг арга хэмжээ авах эрхтэй. Сүүлд хуульчилсан худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотой сэтгүүлчдийн дунд цензуртэй хандах, олон нийтийн улс төрийн харилцаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэдгээ АИХЭГ-т ярилцлага өгсөн хэд хэдэн хүн илэрхийлэв.
- Сонгуультай холбоотой хэргүүдийг шуурхай шийдвэрлэх журам байхгүй. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хугацаа 30 хоног бөгөөд үүнийг 10 хоногоор сунгах боломжтой. Дээд шүүх мөн адил хугацааг баримталдаг. УИХ-ын сонгуулийн тухай хуульд сонгуулийн жилд багтаан шийдвэр гаргахаар зохицуулах боловч энэ нь бусад хуультай зөрчилддөг. Хуульд заасан хугацаанууд нь, АИХЭГ САХ-ны ярилцсан хэд хэдэн хүний хэлснээр, үр дүнтэй хуулийн арга хэмжээ авах байдлыг алдагдуулж байж болзошгүй. Сонгуулийн жил эхэлснээс хойш 5-р сарын 29-ний өдрийг хүртэл цагдаагийн байгууллагад захиргааны болон эрүүгийн гэмт хэргийн шинжтэй 56 гомдол, 6 дугаар сарын 7-ны өдрийн

байдлаар СЕХ-ноос нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг эсэргүүцсэн 15 гомдол захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд ирсэн байна.

- Сонгуулийн хуулиар иргэд, олон улсын ажиглагчид сонгуулийн бүхий л үйл явцад ажиглалт хийх боломжтой. Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүд сонгуулийн үйл явцыг тал бүрээс ажиглаж, санал хураах өдөр Улаанбаатар хот болон бусад сонгогдсон аймгуудад 300 ажиглагч томилон ажиллуулахаар зорьж байна.

II. ТАНИЛЦУУЛГА

Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын (ЕАБХАБ) Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газраас (АИХЭГ) тус улсын эрх бүхий байгууллагуудын урилгаар Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагааг ажиглахаар Сонгууль Ажиглах Хороог (САХ) 5-р сарын 21¹-ний өдөр байгуулав. Улаанбаатар хотод байршин ажиллах 11 мэргэжилтнээс бүрдсэн тус хороог Элчин Сайд Женнифер Браш удирдах бөгөөд орон нутагт урт хугацааны 18 ажиглагчийг томилж ажиллуулна. ЕАБХАБ-ын 22 гишүүн орноос сонгогдсон тус хорооны гишүүдийн 45% нь эмэгтэйчүүд юм. АИХЭГ-аас сонгуулийн өдрийн үйл явцыг ажиглах богино хугацааны 250 ажиглагчийг гишүүн орнуудаас ирүүлэх хүсэлт илгээгээд байна.

III. ҮНДЭСЛЭЛ, УЛС ТӨРИЙН БАЙДАЛ

Монгол Улс нь УИХ-аар баталсан Ерөнхий сайдаар ахлуулсан засгийн газартай, шууд сонгуулиар сонгогдсон Ерөнхийлөгч төрийн тэргүүний үүрэг гүйцэтгэдэг, хагас ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс юм. Эрх баригч Монгол Ардын Нам (МАН) сүүлийн найман жилийн хугацаанд улс төрийн тавцанд ноёрхож, мөн сүүлийн хоёр УИХ-ын сонгуулиар үнэмлэхүй олонхыг бүрдүүлж, улмаар 2021 оны Ерөнхийлөгчийн² сонгуулиар ялалт байгуулж, эрх мэдлээ улам бататгасан.

2023 оны 5-р сард Үндсэн Хуульд томоохон өөрчлөлт оруулснаар 2023 оны 12-р сарын 28-ны өдөр ирэх сонгуулийг зарласан. Уг нэмэлт өөрчлөлтөөр, сонгуулийн тогтолцоог өөрчилж, парламентын бүрэлдэхүүнийг нэмж, парламентыг илүү хүчирхэг, олон талт болгох зорилгоор холимог сонгуулийн тогтолцоог нэвтрүүлсэн.³ АИХЭГ-ын САХ-ны ярилцсан хүмүүсийн дийлэнх нь сонгуулийн шинэ тогтолцоонд эерэг хүлээлттэй байгаа боловч шинэ сонгуулийн тойрог нь сонгуулийн албан ёсны сурталчилгааны богино хугацаанд орон даяар хүрч ажиллах хүчин чадалтай голлох улс төрийн намуудад илүү давуу талтай гэдэгт санаа зовж байгааг илэрхийлж байв.

Авлига, хээл хахууль нь гол сэдвүүдийн нэг хэвээр байгаа бөгөөд сүүлийн нэг жилийн⁴ хугацаанд хэд хэдэн томоохон хэргүүд олон нийтийн дунд яригдсаар байна. 2022 оны 4-р сард авлига, хээл хахууль, засгийн газрын үйл ажиллагаа үр дүнгүй байгааг эсэргүүцсэн жагсаал цуглаан болсон

¹ [АИХЭГ-ын Монгол улсын сонгуулийг ажигласан тайлан](#)гийн өмнөх хувилбараас харна уу.

² 2020 оны УИХ-ын сонгуульд МАН 62 суудал, АН 11 суудал, “Та бидний эвсэл”, “Зөв хүн электорат эвсэл”, бие даан нэр дэвшигч тус бүр нэг суудал авсан. 22 сайд бүгд, 21 Засаг даргын 14 нь МАН-аас томилогдсон.

³ Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр УИХ-ын гишүүдийн тоо 76 байсныг 126 болгож, сонгуулийн тогтолцоог цэвэр мажоритараас холимог тогтолцоонд шилжүүлсэн.

⁴ Үүнд, 2023 оны 5-р сард илэрсэн Боловсролын зээлийн сангийн зээлтэй холбоотой дуулиан; 2023 оны 6-р сарын Нийслэлийн нийтийн тээвэрт зориулсан 1000 ширхэг автобус худалдан авах төсөв хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан гэх хэрэг; Ерөнхий сайд асан, одоогийн УИХ-ын гишүүн Сүхбаатарын Батболд 14 сая ам.доллар (ойролцоогоор 12.9 сая евро) болох төрийн мөнгийг шамшигдуулсан, улмаар Нью-Йоркийн орон сууц худалдаж авсан гэх үндэслэлээр АНУ-ын Хууль зүйн яамнаас 2024 оны гуравдугаар сард гаргасан [гомдол](#) зэрэг багтана.

бол мөн оны 12 сард нүүрсний экспорттой холбоотой авлигын схем илчлэгдсэний дараа томоохон эсэргүүцлийн жагсаал зохион байгуулагдсан. Үүний хариуд, эрх баригчид УИХ-ын Хянан шалгах түр хороог байгуулж, хэд хэдэн өндөр албан тушаалтан, УИХ-ын гишүүдийг баривчилж, авлигын хэргийн хариуцлагыг өндөрсгөж эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулав.

2023, 2024 оны зуд малчдын эдийн засгийн нөхцөл байдлыг улам хүндрүүлсэн. Иймд, 2024 оны 4-р сард малчдын ачааллыг хөнгөвчлөх зорилгоор УИХ-аас шинэ хууль тогтоомжийг шуурхай баталлаа. АИХЭГ-ын САХ-ны хэд хэдэн ярилцагчид одоогийн хууль батлах стандарт үйл явц болон эрх баригчийн сурталчилгаанд шинэ хуулийн заалтыг ашиглаж байгаа талаар шүүмжлэлтэй хандав. Шүүхийн хараат бус байдлын талаар оролцогч талуудын санаа зовнил, сэтгүүлчдэд үзүүлэх дарамт байсаар байна.⁵

Ялгаварлан гадуурхалтын эсрэг хуулийн заалтууд байдаг хэдий ч эмэгтэйчүүдийн төлөөлөл улс төрийн амьдрал, шийдвэр гаргах түвшинд хангалтгүй хэвээр байна. Бүрэн эрх нь дуусаж буй парламентад 13 эмэгтэй (17 хувь), 22 сайдын зөвхөн 3 нь эмэгтэй (14 хувь), 22 засаг даргын мөн 1 нь эмэгтэй байна. АИХЭГ-ын САХ-ны ярилцагчдын дийлэнхийн үзэж буйгаар жендэрийн хэвшмэл ойлголт байсаар байна. Улмаар, хязгаарлагдмал нөөц бололцоо нь эмэгтэйчүүдийг улс төрийн амьдралд ороход саад болдог.

IV. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО БА ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль, эрх зүйн орчин нь 1992 оны Үндсэн Хууль, 2019 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай (МУИХСтХ), 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай (дээрх хуулиудад 2023 онд нэмэлт өөрчлөлт оруулсан), Улс төрийн намын тухай (2023 онд шинэчлэн найруулсан), 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай (сүүлд 2023 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) зэрэг хуулиас бүрддэг.⁶ Монгол Улс нь ардчилсан сонгууль зохион байгуулахтай холбоотой томоохон олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон.⁷

Сонгуулийн хуульд сүүлд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь сонгуулийн тогтолцоог өөрчилсөн Үндсэн Хуулийн өөрчлөлтийг гол төлөв тусгасан байна. Мөн улс төрийн намын бүртгэл, дотоод бүтэц, зохион байгуулалт, төрийн санхүүжилттэй холбоотой өөрчлөлтүүдийг оруулсан байна. Түүнчлэн, сүүлд оруулсан өөрчлөлтүүдэд сонгууль товлон зарласнаас хойш байгуулагдсан намуудад нэр дэвшүүлэх боломжийг олгосон, нэр дэвшигчдийн хүйсийн квотыг өсгөсөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлсэн улс төрийн намуудад олгох санхүүгийн урамшууллыг тусгасан зэрэг өөрчлөлтүүд багтаж байгаа хэдий ч сонгох эрх болон үг хэлэх эрх чөлөөг хязгаарласан, хуулийн цоорхой, тодорхойгүй байдал хууль, эрх зүйн орчны хувьд байсаар байна. АИХЭГ-аас удаа дараа өгсөн сонгох эрх болон үг хэлэх эрх чөлөөтэй холбоотой хязгаарлалт, сонгуулийн хэрэг маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх хугацаатай холбоотой зөвлөмжүүдийг орхигдуулсан хэвээр байна.

⁵ Дараах тайлангуудыг харна уу: [Хуульч, шүүгчдийн хараат бус байдлын тусгай илтгэлийн урьдчилсан ажиглалт, 2023 оны 11-р сар](#); [Дэлхийн эрх чөлөөний тайлан 2023](#); [Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23-р илтгэл](#), Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс; [Монгол улсын хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2022-2023](#), Глоб Интернейшнл Төв.

⁶ Үүнд 2015 оны Эрүүгийн хууль, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2012 оны Зөрчлийн тухай хууль, 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль, 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон 2006 оны Авлигын эсрэг хууль мөн багтана.

⁷ Үүнд 1966 оны Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1979 оны Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, 1965 оны Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, 2003 оны Авлигын эсрэг НҮБ-ын конвенц болон 2006 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц багтана.

Улсын Их Хурлын 78 гишүүнийг сонгуулийн 13 тойргоос олныг төлөөлөх буюу мажоритар аргаар, үлдсэн 48 гишүүнийг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн нэг тойргоос хувь тэнцүүлэн төлөөлөх буюу пропорциональ аргаар сонгоно.⁸

Сонгуулийн тойрог байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолд шалгуур үзүүлэлтийн талаар дурдаагүй боловч МУИХСтХуульд сонгуулийн тойргийг байгуулахдаа хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан байгуулахаар заасан. Арван гурван сонгуулийн тойргийн арван нэгийнх нь сонгогчдын тоо сонгогчдын дундаж тооны хязгаараас 15 хувиар хэтэрсэн байгаа ба үүнээс Улаанбаатар хотын 4 тойрог 50 хувиар хэтэрсэн үзүүлэлттэй байна.⁹

V. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Сонгуулийг дөрвөн шат бүхийн сонгуулийн байгууллага зохион байгуулна. Сонгуулийн Ерөнхий Хороо нь байнгын ажиллагаатай, есөн гишүүнээс бүрдэх байгууллага бөгөөд одоогоор нэг эмэгтэй гишүүнтэй. СЕХ-ны гишүүд нь зургаан жилийн хугацаатай томилогддог ба УИХ-аас тав, Ерөнхийлөгч болон Дээд шүүхээс тус бүр хоёр гишүүн нэр дэвшүүлж томилдог.¹⁰ СЕХ нь сонгууль зохион байгуулах өөрийн өргөн хэмжээний бүрэн эрхийн хүрээнд доод шатны сонгуулийн түр хороодын гишүүдийг томилох үүрэгтэй ажилладаг.

СЕХ нь энэ удаагийн сонгуулийг зохион байгуулахаар аймаг нийслэлийн сонгуулийн 22 хороо (АНСХ), сум дүүргийн сонгуулийн 339 хороо (СДСХ), хэсгийн 2198 хороог (СХХ) байгуулан ажиллаж байна¹¹. Санал хураах байрны түвшинд ажиллах хэсгийн хороодыг хуульд заасан хугацаандаа буюу 5-р сарын 14-ний өдөртөө багтааж байгуулж чадаагүй ба энэ нь СЕХ-оос шинээр нэвтрүүлж буй цахим системтэй холбоотой байсан юм.¹² СХХ-ны гишүүд шинэ цахим системээр дамжуулан онлайн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авах шаардлагатай болсон байна. Ийнхүү хуулийн хугацаанаас хоцорсон нь СХХ-ны ажилд нөлөөлсөнгүй, тэд зургаадугаар сарын 3-ны өдөр сонгогчдын нэрийн жагсаалтыг баталгаажуулах ажлаа эхлүүлэх боломжтой болсон юм.

АИХЭГ-аас хийсэн уулзалтад оролцогчдын дийлэнх нь сонгууль зохион байгуулах бүх шатны байгууллагад итгэдэг тухай дурдсан ба тэдгээрийн үйл ажиллагаа нь хараат бус, ил тод байдаг тухай мөн онцлон тэмдэглэжээ. СЕХ нь өөрийн цахим хуудсанд өөрсдийн гаргасан шийдвэр, журмуудыг нийтлэхээс гадна иргэдэд зориулсан сонгуулийн боловсролыг дээшлүүлэх мэдээ, мэдээллийг мөн түгээж байна.¹³ СЕХ болон бусад шатны сонгууль зохион байгуулах хорооны хурлын тов нь олон нийтэд нээлттэй бус, болж өнгөрсөн хурлын тэмдэглэл тогтмол

⁸ Сонгуулийн тойргийн тоо нь 29-өөс 13 болж багассан. 13 сонгуулийн тойрог бүрд УИХ-ын гишүүдийг сонгогчид тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тоогоор олон нэр дэвшигчдийг сонгох системээр сонгоно.

⁹ 2002 оны Венецийн комиссын Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын дүрмийн I.2.2.iv дэх хэсэгт онцгой тохиолдлоос бусад нөхцөлд тогтоосон норм хэмжээнээс 15 хувиас хэтрэхгүй байхыг зөвлөдөг.

¹⁰ СЕХ-ны гишүүд нь төрийн албан хаагчид байх ба албан тушаал хаших хугацаандаа улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.

¹¹ Монгол Улсын хилийн чандад байгаа иргэддээ зориулан ГХЯ-д мөн тусдаа сонгуулийн хороо байгуулсан бөгөөд 37 улсад 47 сонгуулийн хэсгийн хороо байнуулжээ. Хилийн чандад дахь сонгогчид нь намын жагсаалтаар санал хураалтад оролцох юм.

¹² [Цахим систем](#) нь бүх шатны сонгуулийн хороодын гишүүдийг бүртгэх, цахим сургалтад хамруулах, багламж олгохоос гадна нэр дэвшигчдийг бүртгэх, ажиглагч иргэдийг бүртгэх зэргээр ашиглагдаж байна.

¹³ [СЕХ-ны цахим хуудас](#) нь харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэйгээр хийгдсэн байна.

нийтлэгдэхгүй байна. АИХЭГ-ын Сонгууль ажиглах хороо байгуулагдсанаас хойш СЕХ-ны 6-р сарын 5-ны өдрийн нэг л хуралд уригдсан.

Сонгуулийн шинэ холимог тогтолцоогоор хоёр саналын хуудас хэрэглэх ба нэг нь пропорциональ саналын хуудас, хоёр дахь нь мажоритар саналын хуудас байх юм. Санал хураах байр тус бүр саналын хуудас сканердах, санал тоолох, саналын хуудас хадгалах зэрэг үйлдлийг хослуулсан цахилгаан төхөөрөмжтэй байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу санал тоолох автоматжуулсан төхөөрөмжөөр санал авах байрны саналын хуудас тоолж дууссаны дараа гараар дахин тоолох зохицуулалт шинээр орсон бөгөөд 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар уг заалтыг хэрэгжүүлсэн байна. Хуульд санал тоолох төхөөрөмжийн тооллогын дүнг албан ёсных хэмээн заасан ч төхөөрөмж болон гар тооллогын зөрүүг хэрхэн зохицуулах тухай заалт тусгагдаагүй. АИХЭГ-ын САХ оролцогч талуудтай уулзалт хийх явцад цахим төхөөрөмжөөр саналын хуудас тоолж байгаад санаа зовниж буй талаар ярьсан хэдий ч, тэрхүү төхөөрөмжийг хэрхэн буруу тоолох талаар, эсвэл санал хураалтын дүн гаргахад хэрхэн нөлөөлж болох тухай нотолж чадаагүй юм. СЕХ-ны зүгээс санамсаргүй байдлаар сонгосон төхөөрөмжүүдийн ажиллагааг оролцогч талуудын хамтаар шалгахар төлөвлөж байгаа хэдий ч төхөөрөмжийн программ хангамж, техник хангамжийн хараат бус баталгаажуулалт хийх, гэрчилгээ олгосон байх тухай хуульд заагаагүй болно.

СЕХ-ноос ирэх сонгуулийн талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг тэлэх, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сонгогчдод зориулсан мэдээллийн иж бүрэн кампанит ажил зохион байгуулж байна. Орон нутгийн хэмжээнд АНСХ, СДСХ, СХХ нь сонгуулийн өдөр мөрдөх журмыг олон нийтэд биетээр үзүүлэх замаар сонгогчдын боловсрол олгох үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тус бүрийн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох телевиз (ТВ), сонин хэвлэл, онлайн хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээтэй шууд хамтран ажиллаж байна. Түүнчлэн зарим АНСХ нь орон нутгийн ИНБ-уудтай хамтран залуу сонгогчид, эмэгтэйчүүдэд зориулж сонгогчдын мэдээллийг түгээжээ.¹⁴

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд саналаа хараат бусаар өгөхөд зориулж СЕХ Брайл саналын хуудасны хүрээ хийх, томруулдаг шил бэлдэх, санал хураах байр болгонд тэргэнцэртэй иргэдэд зориулсан налуу зам бэлдэхээр ажиллаж байна. Мөн сонгогчдод зориулсан мэдээллийн видео бэлдэхдээ дохионы хэлний хэлмэрчтэй хийж олон нийтийн болон хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулахаас гадна цахим талбаруудад мөн байршуулсан байна.

VI. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

Санал хураах өдөр 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн бүр санал өгөх эрхтэй. Гэмт хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж буй бүх этгээд, эрх зүйн чадамжгүй тухай шүүхийн шийдвэр гарсан иргэдийн сонгох эрхийг нь хязгаарласан байдаг.

Сонгогчийн бүртгэл нь сонгогчийн оролцоогүй хийгддэг ба УБЕГ-аас тогтмол шинэчлэгддэг Монгол Улсын иргэний бүртгэлийн нэгдсэн сангаас хувийн болон биеийн давтагдашгүй өгөгдөл мэдээллийг үндэслэн сонгогчийн нэрсийн жагсаалт гаргаж авдаг байна. Санал авах үед сонгогч нь өөрийн биеийн давтагдашгүй өгөгдлөө ашиглан өөрийгөө таниулах бөгөөд, иргэний бүртгэлийн нэгдсэн сангаас танигдсан хурууны хээ болон тухайн хүний гэрэл зураг бүхий мэдээлэл гарч ирдэг.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг урьдчилсан байдлаар 2024 оны дөрөвдүгээр сарын 1-ний өдөр УБЕГ-ын цахим хуудсанд нийтэлж, сонгогчдыг баталгаажуулах ажлыг зохион байгуулж эхэлсэн.

Тавдугаар сарын 28-нд УБЕГ-аас сонгогчдын нэрсийн жагсаалтад нийт 2.238.360 сонгогч буйг зарлав. Сонгогчдын нэрийн жагсаалтыг эцсийн байдлаар 6-р сарын 25-нд гаргаж, сонгуулийн хэсгийн хороодод илгээнэ. Сонгогчид өөрсдийн мэдээллээ онлайнаар баталгаажуулах боломжтой, мөн энэ удаагийн сонгуулийн шинэ зохицуулалтаар иргэд өөрсдийн байнгын оршин сууж буй хаяг дээрээ бүртгүүлсэн бүх хүмүүсийн бүртгэлийг шалгах боломжтой. Түүнчлэн, 6-р сарын 3-наас 25-ны хооронд сонгуулийн хэсгийн хороонд өөрсдийн бүртгэлийн мэдээллийг биечлэн баталгаажуулах, сонгууль болохоос 14 хоногийн өмнө өөрсдийн мэдээллийг өөрчлөх тухай хүсэлт гаргах боломжтой. Бүртгэлтэй улс төрийн нам, эвслийн хүсэлтийн дагуу УБЕГ-аас сонгогчдын нэрийн жагсаалтыг зургаадугаар сарын 8-ны өдөр цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

Ерөнхийдөө сонгуулийн санал авах өдрөөс 60 хүртэлх хоногийн өмнө сонгогчийн хаягийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг хориглоно.¹⁵ Сүүлийн хоёр жилийн хугацаанд олон тооны сонгогчид сонгуулийн нэг тойргоос нөгөө тойрогт зориудаар шилжин суурьших болсон тухай АИХЭГ-ын САХ-нд зарим хүмүүс санаа зовниж байгаагаар илэрхийлжээ. Түүнчлэн САХ-ны уулзсан хүмүүс зарим аймгийн сонгогчдод нэр дэвшиж буй ажил олгогчоос нь дарамт шахалт ирдэг тухай ярьсан билээ. Тухайлбал, нэр дэвшиж буй ажил олгогчийн сонгуулийн тойрог руу хаягаа шилжүүлэхийг шахаж шаардаж өөрсдийн авах саналын тоог нэмэгдүүлж байгааг мэдээлэв. Сүүлийн саруудад 70,000 орчим иргэний шилжилт хөдөлгөөн (хаяг бүртгэлийн өөрчлөлт) явагдсан тухай УБЕГ-аас АИХЭГ-ын САХ-нд мэдээлсэн ба эдгээр шилжилт хөдөлгөөний дийлэнх хувь нь нийслэлд байсан тухай мөн дурджээ.¹⁶

Мөн зарим сонгогчид, тэр дундаа уурхайчид болон оюутнууд, сонгуулийн өдөр санал өгөх боломжтой байх эсэх тухай санаа зовниж байсан. Ажил олгогч нь ажилчдаа санал өгөх боломжоор хангах хуулийн үүрэгтэй ч их, дээд сургуулийн оюутнуудад үүнтэй адил боломж олгох хуулийн зохицуулалт байхгүй байна.¹⁷

VII. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

Улс төрийн нам, эвслүүд сонгуульд оролцох тухайгаа санал авах өдрөөс 60-аас доошгүй өдрийн өмнө Сонгуулийн Ерөнхий Хороонд (СЕХ) мэдэгдэнэ. Түүнчлэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид өөрсдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Үндэсний Аудитын Газарт (ҮАГ) хүргүүлэх ёстой. ҮАГ-аас мөрийн хөтөлбөрүүд Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцэж байгаа эсэх, төлөвлөсөн төсөв нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцэж буй эсэхийг тус тус шалгана. Үүний дараа хууль тогтоомжид нийцэж буй талаар мэдэгдсэнээр, нэр дэвшигчид СЕХ-нд бүртгүүлэх хүсэлтээ илгээнэ.

Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн улс төрийн нам, эвслүүд сонгуулийн санал авах өдрөөс 45 хоногийн өмнө нэр дэвшигчээ тодруулах ажлаа эхлүүлж 7 хоногийн дотор дуусгах ёстой. Хууль тогтоомжид зааснаар ижил хугацаанд дор хаяж 801 хүний гарын үсэг цуглуулсан тохиолдолд бие даан нэр дэвшихийг зөвшөөрдөг. Түүнчлэн, нийт нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль

¹⁵ Сонгуулийн хорооны албан хаагчид, цагдаагийн бие бүрэлдэхүүн, иргэний бүртгэлийн албаны төлөөлөл, мэдээлэл технологийн ажилчид санал авах өдрөөс 14 хоногийн өмнө өөрсдийн санал өгөх газраа солих боломжтой юм.

¹⁶ 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 4 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд нийслэлийн хэмжээнд 42.750 хүн шилжилт хөдөлгөөн хийсэн бол 9.420 хүн нийслэлээс орон нутаг уруу, 11.389 хүн орон нутагас нийслэл уруу, 6.512 хүн аймаг хооронд шилжилт хөдөлгөөн хийжээ. УБЕГ-ын тоо баримт нь байнгын оршин суух хаяг солих болсон шалтгааныг агуулаагүй байна.

¹⁷ Хуулийн заалт хэрэгжүүлээгүй тохиолдолд хувь хүн 10.000 (ойролцоогоор 2.7 евро) төгрөгөөр, хуулийн этгээд 100.000 (ойролцоогоор 27.4 евро) төгрөгөөр торгууах заалттай.

нэг хүйсийнх байх, пропорциональ намын жагсаалтад нэр дэвшигчдийн хүйсийг сөөлжүүлж оруулахаар хууль тогтоомжид заасан.

25 нас хүрсэн иргэн сонгуульд нэр дэвших эрхтэй. Шүүхийн шийдвэрээр зээл, барьцаа, батлан даалтын өртэй, татварын хугацаа хэтэрсэн өртэй, нэр дэвшигчийн 51 хувиас дээш хувийг эзэмшдэг компани албан татварын хугацаа хэтэрсэн өртэй бол, хэрэв нэр дэвшигч сүүлийн 6 жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан бол нэр дэвших эрхгүй болно. Авлига, эрх мэдлээ урвуулан ашигласан гэмт хэрэг үйлдсэн, ял эдэлж буй хүмүүс нэр дэвших эрхгүй. Түүнчлэн, төрийн зарим ангиллын албан хаагч, төрийн болон орон нутгийн захиргааны бүрэн буюу хэсэгчлэн өмчилдөг байгууллагын дарга, орлогч дарга, захирал, дэд захирал сонгуульд нэр дэвшихээр бол сонгуулийн жилийн 1-р сарын 1-ний өдрөөс өмнө албан тушаалаасаа чөлөөлөгдөх ёстой.

Нам, эвслүүд тойрог тус бүрд байгаа мандатын тоогоор нэр дэвшүүлж болно. Мажоритар сонгуульд 78 хүртэл, пропорциональ сонгуульд 48 хүртэл хүн нэр дэвшүүлж болно. Нэр дэвшигч зөвхөн пропорциональ тойрогт эсвэл зөвхөн мажоритар тойрогт нэрээ дэвшүүлж болно.

Мажоритар болон пропорциональ сонгуульд 19 улс төрийн нам, 2 эвсэл, 1336 нэр дэвшигч (817 эрэгтэй, 519 эмэгтэй) бүртгүүлснийг 6-р сарын 10-ны өдөр Сонгуулийн Ерөнхий Хорооноос мэдээллээ. Мөн мажоритар сонгуульд 42 бие даан нэр дэвшигч бүртгүүлсэн байна. 11 нэр дэвшигч бүртгэлийн болзол хангаагүй тул өөр өөр үндэслэлээр бүртгэхээс татгалзжээ¹⁸. Сүүлийн үеийн эрх зүйн өөрчлөлтөөр улс төрийн намуудад санхүүгийн урамшуулал олгох замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нэр дэвшигчийн жагсаалтад оруулахыг дэмжиж байна. Энэ удаагийн сонгуульд хэд хэдэн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигч бүртгэгдсэн.

VIII. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ОРЧИН

Сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаа 6 сарын 10-ны өдөр эхэлж 17 хоног үргэлжлэх бөгөөд сонгуулиас нэг өдрийн өмнө сурталчилгаа зогссон байна. АИХЭГ САХ-ны ярилцлагад сурталчилгааны хугацааг харьцангуй богино, сонгуулийн тойргийг томсгосон нь жижиг намууд болон шинэ нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгааг үр дүнтэй биечлэн явуулах, сурталчилгааны материалыг тараахад бэрхшээл учруулж буйг онцлон тэмдэглэв. Албан ёсны сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө албан бусаар, ялангуяа цахимаар өөрсдийн ололт амжилтыг сурталчлах боломжтойг олон ярилцагч онцлон тэмдэглэв. Ихэнх улс төрийн намууд эдийн засгийн хөгжил, байгаль орчны асуудлуудыг хөндөж тавьж буй бол зарим нь авлигатай тэмцэх, залуучуудын ажилгүйдэл, эдийн засгийн төрөл зүйлсийг онцолж байна.

Өрсөлдөгчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт бэлэн мөнгө, эд зүйлс, хувьцаа өгөх, үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэхээр амлахыг хориглоно. Сонгуулийн жилийн 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн тухайн жилийн улсын төсөвт тусгаагүй халамжийн хөтөлбөр хэрэгжүүлэх, шинээр зарлахыг хориглоно. Засгийн газар 2024 оны 1-р сараас төсөвт тусгагдсан нийгмийн халамжийн хэд хэдэн шинэ төлбөр, олборлох үйлдвэрлэлийн орлогоос 2 удаа ашиг олгох, зээлийн томоохон хөтөлбөр, Үндэсний баялгийн сан байгуулах гэх мэт зүйлсийг хэрэгжүүлэхээр зарласан¹⁹. Нэр

¹⁸ Гурван нэр дэвшигч татварын өртэй, гурван нэр дэвшигчийн бичиг баримтын бүрдэл дутуу, дөрвөн нэр дэвшигч нэр дэвшүүлсэн намаасаа өөр намын гишүүн, нэг нэр дэвшигч төрийн албан тушаалаас хуульд заасан хугацаанд чөлөөлөгдөөгүй байна.

¹⁹ Өнгөрсөн 1-р сард “Эрдэнэс Тавантолгой” төрийн өмчит хувьцаат компани 2012 оноос хойш төрсөн 893,432 хүүхдэд хувьцаа олгож, 2024 оны 4 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн нийт хувьцаа эзэмшигчдэд 256,000 төгрөгийн (ойролцоогоор 70 евро) ноогдол ашиг олгосон. Засгийн газрын 2024 оны 3 сарын 20-ны өдрийн шийдвэрээр тэтгэврийг 2024 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн 100000 төгрөгөөр (ойролцоогоор 27 евро) нэмсэн. 2024 оны 4 сарын 3 сарын 27-ны өдөр төрийн албан хаагчдын цалинг 4 сарын 1-ээс эхлэн нэмсэн. 4

дэвшигч нь өөрийн албан үүргээ гүйцэтгэх болон нэр дэвшигчийн хувиар үйл ажиллагаанд оролцохыг зааглах тухай хуулийн шаардлага байхгүй байна. Ярилцлагад оролцогсдын ихэнх нь сонгуулийн сурталчилгаанд улсын хөрөнгийг зарцуулж байгаад санаа зовниж буйгаа илэрхийлж байв.

Сонгуулийн сурталчилгаанд оролцох эрх бүхий ажилтны тоо, төрөл, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл зэрэгт хууль тогтоомжийн дагуу хязгаарлалт тавьдаг. Сонгуулийн өдрийг дуустал бойкот зарлах, санал асуулга явуулах, нийтлэхийг хориглоно. Сурталчилгааны материалыг зөвхөн дүүргийн засаг даргын тогтоосон сурталчилгааны самбарт байрлуулах боломжтой. Зурагт хуудсыг зөвхөн улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн штабт байрлуулж болно. АИХЭГ САХ-ны ярилцагчдын дурдсанаар сонгогчдын саналыг худалдаж авах, бэлэн мөнгө тараах, төрийн албан хаагчдыг дайчлах, дарамт шахалт үзүүлэх зэрэг асуудлууд үргэлжилсээр байна.

Сурталчилгааг цахимаар явуулах зохицуулалттай бөгөөд хяналт, шалгалтыг Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ)-ноос төрийн бусад байгууллагуудтай хамтран явуулдаг. Өрсөлдөгчид сонгуулийн сурталчилгаа явуулахын тулд тусгайлсан цахим хуудас, олон нийтийн сүлжээний хаягаа СЕХ-нд бүртгүүлэх шаардлагатай ба сурталчилгаанд өөр хаяг ашиглахыг хориглоно. АИХЭГ-ын САХ-ны зарим ярилцагчид олон нийтийн сүлжээгээр зохион байгуулалттайгаар худал мэдээлэл цацах үйл ажиллагаа их хэмжээгээр өрнөж буйд санаа зовниж буйгаа илэрхийллээ.²⁰

Сонгуулийн сурталчилгааг үндэсний цөөнхийн төрөлх хэлээр явуулж болно.²¹ Өнгөрсөн сонгуулиар тойргийг шинэчлэн тогтоохдоо Улсын Их Хурлаас Монгол Улс дахь хамгийн олон үндэсний цөөнх буюу Казак үндэстэн амьдардаг Баян-Өлгий *аймгийг* иргэдийнх нь Улсын Их Хурал дахь төлөөллийг хангах зорилгоор сонгуулийн нэг тойрог болгон салгасан байна.

Сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих арга хэмжээ авч байгаа ч АИХЭГ-ын САХ-ны ихэнх ярилцлагад эмэгтэй нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны ажилд хангалттай хөрөнгө бүрдүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй тулгардгаас гадна жэндэрийн уламжлалт хэвшмэл ойлголтуудаас үүдэлтэй саад бэрхшээлүүд их байгааг онцолж хэллээ.

IX. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар сүүлийн Улсын Их Хурлын сонгуулиар нэг хувиас дээш санал авсан намуудад төрийн санхүүжилт олгохоор хуульчилсан.²² Сонгуулийн сурталчилгааг иргэн, хуулийн этгээдээс тогтоосон хязгаарын хүрээнд авсан хандив болон нам, нэр дэвшигчийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой.²³ Сонгуулийн сурталчилгаатай

сарын 19-нд Стратегийн уул уурхайн тодорхой ордуудын ноогдол ашгийн 34 хувийг авах Үндэсний баялагийн сан байгуулах УИХ-аас хууль тогтоомжийг өргөн хүрээтэй хэлэлцэн баталсан. 2024 оны 4 сарын 24-ний өдөр малчдыг дэмжих зорилготой “Шинэ хоршооллын хөдөлгөөн” зээлийн хөтөлбөрийг танилцуулж, улсын төсөвөөс 5 их наяд (ойролцоогоор 1.4 тэрбум евро) төсөвлөсөн нь он гарсаар төлөвлөгдөөгүй зардал юм.

²⁰ ХХЗХ нь цагдаа, тагнуулын байгууллагын саналыг үндэслэн зарим контентын тархалтыг зогсоохын тулд интернэтийн урсгалыг хязгаарлах, нийгмийн сүлжээ, цахим хуудаснуудыг хаах эрхтэй.

²¹ [2020 оны Хүн ам, орон сууцны тооллогоос](#) үзэхэд, Казак хүмүүс хамгийн том үндэсний цөөнхөд (3.8 хувь) тооцогдож байна.

²² Энэхүү санхүүжилтийн тавин хувийг иргэд болон намын гишүүдийг чадавхжуулах, боловсрол олгох болон хөтөлбөр, бодлого боловсруулах зориулалтаар зарцуулахаар тусгасан.

²³ Мөнгөн хандив нь иргэний хувьд арван сая хүрэл (2,750 орчим евро), хуулийн этгээдийн хувьд гучин сая төгрөг хүртэл (8,250 орчим евро) байна.

холбоотой бүхий л гүйлгээг Төрийн аудитын дээд байгууллагад бүртгүүлсэн банкны дансаар хийх ёстой.

Сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийг хянах үндсэн байгууллага болох Төрийн аудитын дээд байгууллага нь сонгуулийн сурталчилгааны зардлын дээд хэмжээг сонгуулийн тойргийн хэмжээ, байршил, түүнчлэн өрх болон сонгогчдын тоог харгалзан тодорхой аргачлалаар тогтоодог. Энэ удаагийн сонгуулиар нам болон эвсэл нь 6.4 тэрбум (1.7 сая орчим евро) төгрөг зарцуулах боломжтой байна. Сонгуулийн тойргоос хамаарч нэр дэвшигчид 0.9 - 1.5 тэрбум (244,000-407,000 орчим евро) төгрөг зарцуулах боломжтой байна. АИХЭГ-ын САХ-той уулзаж ярилцсан хүмүүс зардлын дээд хэмжээ өндөр байгаа нь голлох намуудад давуу байдал бий болгоно гэж үзэж байна. Төрийн аудитын дээд байгууллага нь хуулиараа сонгуулийн сурталчилгааны санхүүжилт болон зарцуулалтад бие даан болон бусад байгууллагуудтай хамтран хяналт тавих эрхтэй боловч энэ чиг үүргийн хүрээнд ямар нэгэн үйл ажиллагаа авч хэрэгжүүлдэггүй байна.

2020 оны УИХ-ын сонгуулиас хойш нэр дэвшигчид хандивын болон зардлын явцын тайлангаа Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлж санал авах өдрөөс гурав хоногийн өмнө олон нийтэд мэдээлдэг болсон. Нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан эцсийн тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан хүргүүлэх үүрэг хүлээдэг. Төрийн аудитын дээд байгууллага нь зөрчил гарсан тохиолдолд хариуцлага тооцох эрх хэмжээгүй ба харин холбогдох эрх бүхий байгууллагууд руу шилжүүлдэг.²⁴

Х. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс 400 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй, олон ургалч хэвлэл мэдээллийн орчинтой. Интернэтийн хэрэглээ өндөр байгаа нь нийгмийн сүлжээ, ялангуяа Facebook-ийн ач холбогдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулаад зогсохгүй, телевизээс гадна мэдээлэл авах үндсэн эх сурвалж болдог. Долоон сувагтай МҮОНРТ-д олон нийтийн итгэх итгэл харьцангуй өндөр. АИХЭГ-ын САХ-ны ярилцсан хэд хэдэн хүмүүс хэвлэлийн эрх чөлөөний байдалд санаа зовж байгаагаа илэрхийлж, бүтцийн янз бүрийн асуудлууд, тэр дундаа эдийн засгийн тогтвортой²⁵ байдлын талаар онцлов.

Ихэнх хэвлэл мэдээллийн хэрэгсэл хувийнх бөгөөд зар сурталчилгааны маш хязгаарлагдмал зах зээл дээр өрсөлддөг. Тэдгээрийн дийлэнх нь санхүүгийн хувьд боломж муу, тэр утгаараа улс төрийн шууд хамааралтай эсвэл эздээсээ хараат хэвээр байна. АИХЭГ-ын САХ-ны ярилцсан хэд хэдэн хүний ярьснаар, ихэнх эздийн хувьд хэвлэл мэдээллийн суваг тэдний үндсэн бизнес биш; харин эдийн засгийн ашиг сонирхлоо хамгаалахын тулд улс төрийн хөшүүрэг болгон ашигладаг байна. Түүнчлэн, сэтгүүлчдийн дунд гэрээгээр ажиллах тогтолцоо түгээмэл бөгөөд өөрсдийн хүссэн контент цацах төлбөрийг санал болгодог.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг Үндсэн Хуулиар олгосон бөгөөд хэвлэл мэдээллийн нарийвчилсан тогтолцоог мөн хуульчилж өгсөн. 2017 онд гүтгэх гэмт хэргийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн хэдий ч улмаар 2020 онд гүтгэлэг, худал мэдээлэл тараасан тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хуулийн хориг, шийтгэлийг чангаруулжээ. Одоогоор, хэд хэдэн

²⁴ Хандив өгөхийг зөвшөөрсөн хүн хандив өгсөн эсэхийг Татварын улсын байцаагч; тайлантай холбоотой асуудлаар Сангийн яам; нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлаар Төв банк.

²⁵ Хил хязгааргүй Сэтгүүлчид тайлангаас харна уу, [Хэвлэлийн эрх чөлөөний индекс 2024: Монгол улс](#).

сэтгүүлчид төрийн байгууллага, томоохон улстөрчид, төрийн албан хаагчдын²⁶ гаргасан гомдлын дагуу шалгагдаж байна. Хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилт нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйг боомилж, өөртөө цензуртэй хандах, олон нийтийн улс төрийн харилцаанд сөргөөр нөлөөлж байгааг АИХЭГ-ын хэд хэдэн ярилцагч тэмдэглэв.

Харилцаа холбооны зохицуулах хорооны журмаар нэмэлтээр оруулсан УИХ-ын сонгуулийн тухай хуульд сонгуулийн сурталчилгааг өргөн мэдээллийн хэрэгсэл, интернэтээр явуулахаар заасан. МҮОНРТ-ээс нэр дэвшигчдэд мэтгэлцээний үеэр болон эфирээр үнэгүй цаг олгох үүрэгтэй. 6-р сарын 10-ны байдлаар улс төрийн субъектууд болон бие даан нэр дэвшигчдийг оролцуулсан цуврал мэтгэлцээн эхэлсэн. МҮОНРТ-ийн телевиз, радиогоор өдөрт гурван удаагийн мэтгэлцээн явуулахаар Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос баталж, мөн хувийн телевизээр өдөрт нийт 60 минут хүртэлх хугацаанд улс төрийн төлбөртэй контент оруулахыг зөвшөөрсөн. Сонгуулийн хуулиар, нэг нэр дэвшигчийн өдөр тутмын мэдээний хамрах хүрээг таван минутаар хязгаарладаг. Өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн хэрэгсэлд тавих хяналтыг СЕХ, Шударга Өрсөлдөөн, Хэрэглэгчийн Төлөө Газар зэрэг хэд хэдэн байгууллага хариуцан ажиллах бөгөөд ХХЗХ үндсэн зохицуулагчаар ажилладаг. Сонгуулийн хуулиар ХХЗХ-нд өргөн хүрээний эрх мэдэл олгосон.

6-р сарын 1-ний өдрөөс эхлэн АИХЭГ-ын САХ-оос тоон болон чанарын аргачлалыг ашиглан²⁷ нэр дэвшигчид, улс төрийн намуудын албан ёсны сонгуулийн сурталчилгааны өмнөх болон дунд үеийн мэдээллийг үнэлэх зорилгоор Монголын томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мониторинг хийж эхэлсэн. Уг мониторингийн хүрээнд, телевизийн оргил цагийн нэвтрүүлэг, улс төр, сонгуультай холбоотой онлайн контентод анхаарлаа хандуулдаг.

XI. СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

Сонгуулийн хороод шатлан захирах зарчмаар буюу засаг захиргааны бага нэгжийн хорооны шийдвэрт холбогдуулан дээд шатны засаг захиргааны нэгжийн хороонд гомдол гаргадаг. СЕХ-ны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын Дээд Шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэдэг. Санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн СЕХ-ны шийдвэрт холбогдуулан иргэнээс гаргасан гомдлыг Үндсэн Хуулийн Цэц хянан шийдвэрлэдэг. Сонгуультай холбоотой зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг цагдаагийн байгууллага шалгаж дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

Шүүхээр сонгуультай холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэх хурдасгасан журам байхгүй. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүх маргааныг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд энэ хугацааг 10 хүртэл хоногоор сунгаж болно. Улсын Дээд Шүүх хэрэг маргааныг мөн хугацаанд хянан шийдвэрлэдэг. МУИХСтХуульд сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд нь тухайн гомдол, маргааныг сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ гэж заасан нь бусад хуультай зөрчилдөж байна. Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд тогтоосон хугацаа нь зөрчигдсөн эрхийг сэргээх үр нөлөөг бууруулж болзошгүй гэж САХ-той уулзаж ярилцсан хүмүүс үзэж байна.

²⁶ 2023 оны 12 сард худал мэдээлэл тараасан хэргээр саатуулагдаж байсан хамгийн алдартай цахим мэдээллийн сайтуудын нэг Zarig.mn сайтын ерөнхий редактор, эрхлэгчийг 2024 оны 2 сард гэрийн хорионд байхаар сулласан. Сэтгүүлчийг дөрвөн зүйл ангиар буруутгаж, таван жил хүртэл хорих ял оноож магадгүй бөгөөд сонгуулийн дараа буюу 2024 оны долдугаар сарын 1-нд шүүх хурлыг товловсон байна.

²⁷ Үүнд МҮОНРТ (телевиз, радио хоёулаа), хувийн хэвшлийн Eagle TV, Mongol TV, NTV, TV9, TV25, мөн eguur.mn, gogo.mn, ikon.mn, news.mn, zarig.mn зэрэг цахим эх сурвалжууд багтана.

Сонгуулийн он гарснаас хойш 5 дугаар сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд сонгуулийн маргаантай холбоотой 56 гомдол, үүнээс зөрчлийн шинжтэй 35, гэмт хэргийн шинжтэй 21 гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад бүртгэгджээ. Энэ оны 6 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар, СЕХ-ны шийдвэртэй холбоотой Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсантай холбоотой 15 нэхэмжлэл ирснээс 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 3 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 4 маргааныг хянан шийдвэрлэсний дотор СЕХ-ны шийдвэрийг хууль бус болохыг тогтоож, нэр дэвшигчийг нэр дэвших боломжоор хангасан тохиолдол нэг бүртгэгдсэн байна.

ХII. ИРГЭД БОЛОН ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД

СТХ-иар иргэд, сонгуульд өрсөлдөж буй субъектүүдийн хууль ёсны төлөөлөл болон олон улсын байгууллагаас сонгуулийн ажиглалт хийх боломжийг хангажээ. Хуулийн зохицуулалтаар ажиглагчид нэг байгууллагаас нэг санал авах байран дээр 2-оос дээшгүй байх, ажиглалтыг төрийн албан хаагч хийхийг хориглох зэрэг хязгаарлалтууд орсон байна. Нам, эвслүүд мөн өөрсдийн ажиглагчдыг санал авах байранд томилох эрхтэй байдаг байна. Иргэд ажиглалт хийх хүсэлтээ санал хураах өдрөөс 7-с дээшгүй хоногийн өмнө СХХ-нд хүргүүлсэн байх шаардлагатай юм. Олон улсын ажиглагчид СЕХ-оос шууд магадлан итгэмжлэлийг нь олгоно.

“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ” нь хэсэг бүлэг ИНБ-ыг чиглүүлж сонгогчийн бүртгэл, сонгуулийн сурталчилгаа, олон нийтийн цахим сүлжээ, сонгуулийн сурталчилгааны зардал, технологийн хэрэглээг сонгуульд ашиглах зэрэг асуудлаар ажиглалт хийж байна. Энэхүү ИНБ-ын сүлжээ нь Нийслэл болон зарим аймгийн нийт 150 санал авах байранд 300 байнгын ажиглагчийг ажиллуулахаар төлөвлөжээ.

ХIII. АИХЭГ-ЫН САХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

АИХЭГ-ын САХ нь 2024 оны 5-р сарын 21-ний өдөр хэвлэлийн бага хурал хийж, Монгол Улсад үйл ажиллагаагаа эхлүүлэв. САХ-ны тэргүүн болон багийн бусад гишүүд СЕХ, ГХЯ, нам, эвслийн төлөөлөл, ИНБ, хэвлэл мэдээлэл, Монгол Улсад суугаа олон улсын байгууллага, дипломат төлөөлөгчийн газруудтай уулзалт хийжээ. Урт хугацааны ажиглагчид өөрсдийн хариуцсан аймгуудад 5 дугаар сарын 28-ны өдрөөс хойш холбогдох талуудтай мөн уулзалтуудыг хийж ажиллаж байна.

*Энэхүү тайлангийн Англи хэл дээрх хувилбар нь албан ёсны тайлан болно.
Монгол хэл дээрх албан бус орчуулгыг авах боломжтой.*